



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

Судалгаа хийлгэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.4.5, Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.3, 3.2.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “БНСУ-ын аялал жуулчлалын зах зээлийн өнөөгийн байдал, жуулчдын онцлог” судалгааны ажлыг гүйцэтгэх бага үнийн санал ирүүлсэн Дөлгөөн дон ХХК-тай гэрээ байгуулсугай.

2. Гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, судалгааны тайланг 2015 оны 09 дүгээр сарын 01-ний дотор хүлээн авч танилцуулахыг Статистик, судалгаа хариуцсан мэргэжилтэн /Б.Жаргалан/-д үүрэг болгосугай.

3. Судалгааны ажлын зардал болох 4.900.000 /дөрвөн сая есөн зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА

